



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 1590

Арвайхээр

**Зарим арга хэмжээг зохицуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.8, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 57 дугаар хуралдааны тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 39 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар Ковид-19 цар тахлын эсрэг дархлаа сэргээх 3 дугаар тунд аймгийн хэмжээнд хамрагдвал зохих нийт иргэдийн 50 хувиас дээш хамрагдсан тохиолдолд 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс хойш төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд “Шинэ жилийн баяр”-ыг тэмдэглэх эсэх асуудлыг аймгийн Онцгой комиссын хурлаар дахин хэлэлцүүлэхийг аймгийн Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв) нарт даалгасугай.

2.Аймгийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын “Шинэ жилийн баяр”-ын захиалга авахгүй, зохион байгуулахгүй байхыг хоол үйлдвэрлэл, зоогийн газар, ресторан, үйлчилгээний газрын эзэд, удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101254